

Памела Кросслейгээс “Тайжийн төр ба Дайчин улсын мандалт” номд өгсөн шүүмж

МУИС-ийн Түүхийн тэнхимийн багш П.Мягмар

Сүүлийн үед Монголд түүхийн ном олноор хэвлэгддэг болжээ. Ном хэвлэл орширч байгаа нь сайн хэрэг. Гэвч тэдгээр нь шинэ мэдлэг бүтээж, судалгаанд ахиц дэвшил гаргаж байна уу? Энэ нь манай улсын судлаачид, ном хэвлэгчдийн өмнө зайлшгүй тавигдаж буй асуулт бөгөөд үүнтэй холбоотойгоор мэргэжлийн шүүмжийн (review) асуудлыг зайлшгүй хөндөх цаг болжээ. Учир нь, тухайн ном шинэ мэдлэг бүтээж, судалгаанд ахиц гаргаж байгаа эсэхийг мэргэжлийн шүүмжээр үнэлдэг. Манай улсад шинээр хэвлэгдсэн судалгааны ном зохиолд мэргэжлийн шүүмж хийж байна уу? Ер нь шүүмж хийдэг тогтолцоо байна уу?

МУИС-ийн багш, Макс Планкийн Хүрээлэнгийн зочин судлаач Л.Мөнх-Эрдэнийн “Тайжийн төр ба Дайчин улсын мандалт” номын талаарх нэгэн шүүмжийг орчуулж, мэргэжлийн шүүмжийн дөхөм жишээ болгон нийтлүүлж байна. Түүхийн судалгааны бүтээл хэвлэгдээрээ алдартай Брилл (Brill) “Тайжийн төр”-ийг хэвлэжээ. “Брилл”-ээс хэвлэгдсэн аливаа бүтээл нь гурван шатны шүүмжийг туулах бөгөөд бүх шүүмж зохиогчоос хараат бус, нууцаар хийгддэг. Тус хэвлэлийн газар нь салбартаа танигдсан судлаачдаас бүрдсэн редакцийн зөвлөлтэй бөгөөд эхний шатанд зөвлөлийн гишүүд зохиогчийн өгсөн номын төслийг шүүн үзэж, уг төсөлд мэргэжлийн эрдэмтдийн хөндлөнгийн нууц шүүмж явуулах эсэхээ шийддэг. Нааштайгаар шийдсэн нөхцөлд номын гар бичмэлд мэргэжлийн эрдэмтдийн хөндлөнгийн нууц шүүмж (double blind review) хийлгэдэг бөгөөд тэрхүү нууц шүүмж дэмжвэл сая ном хэвлэгдэх боломжтой болдог байна. Эцэст нь, ном хэвлэгдсэний дараа тухайн салбарын эрдэмтдийн зүгээс уншигчдад зориулан шинэ бүтээлд шүүмж өгч, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлнэ. Салбартаа нэр хүндтэй эрдэмтэд нааштай шүүмж өгвөл, тухайн бүтээл тэр хэрээр ач холбогдолтой, үнэ цэнтэй болох нь мэдээж. “Тайжийн төр”-ийн хувьд Манж Чин гүрний түүх судлалын хамгийн шилдэг эрдэмтдийн нэг болох Памела Кросслей шүүмж хийж, тун нааштай үнэлж, салбарынхаа аливаа эрдэмтдийг уг бүтээлийг нарийвчлан судлахыг уриалсан нь тус бүтээлийн ач холбогдлыг илтгэнэ.

Дартмут Коллежийн профессор Памела Кросслей уг шүүмжийг Хонг Конгийн Хятадын Их Сургуулийн (The Chinese University of Hong Kong) Хятад Судлалын Хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Journal of Chinese Studies” сэтгүүлд нийтлүүлжээ. П.Кросслей 1978 онд Йель Их Сургуулийг дорнод Ази судлалын бакалаврын зэрэгтэй төгссөн бөгөөд 1983 онд тус их сургуульд Манж судлалын сэдвээр Ph.D зэрэг хамгаалжээ. Тэрээр Чин гүрэн ба орчин үеийн Хятадын түүх судлалаар мэргэшсэн байна.

Тайжийн төр ба Дайчин улсын мандалт

Памела Кросслей
Дартмут Коллеж

Лхамсүрэнгийн Мөнх-Эрдэнэ нь номадизмын түүх бичлэг хийгээд Монголын түүхийн талаарх жинтэй (substantial), нухацтай (challenging) засваруудаараа (revisions, ревизионист судалгаагаараа) сайтар танигдсан нэгэн. Тэрээр “Тайжийн төр ба Дайчин улсын мандалт” бүтээлдээ Чингийн үеийн Монгол төдийгүй Чин гүрний төрийг өөрийг нь авч үзжээ. Мөнх-Эрдэнийн дүгнэлт эрс хурц (stark): удирдтгалдаа тэрээр хэрвээ Чин нь колонийн эзэнт гүрэн байсан бол колони нь Монгол гэхээсээ Хятад байсан (2-р хуудас) хэмээн шулуухан дэвшүүлжээ. Хэрвээ энэ нь хангалттай тодорхой биш бол, тэрээр “Чин нь Хятадыг амжилттай байлдан дагуулж, “колоничилсон” Дотоод Азийн язгууртны гүрэн болно” хэмээн 10-р хуудсанд нэмж бичжээ. Хэллэг нь хурц, шулуухан ч Мөнх-Эрдэнийн дэвшүүлсэн аргументын онол-арга зүй нь нарийн цогц (complex) бөгөөд тэр нь түүхэн баримт болон түүхэн баримт чухам юу хэлж байна вэ гэдэг асуудлыг ч хамарч байна. Түүний ашигласан сурвалжуудын дотор урьд хэвлэгдэж байгаагүй, Бээжин дэх Хятадын түүхийн нэгдүгээр архив, Монголын Үндэсний төв архивын баримтууд байна. Орчин үеийн бүх судлаачийн адилаар зохиогч хэвлэгдэн гарсан архивын анхдагч сурвалжуудын ашиг тусыг хүртжээ. Тэдгээр сурвалжуудын дотор Нэгдүгээр архивын нэмэлт баримтууд, “Манвен Лаодан” 滿文老檔, “Кайгуо Фанлүэ” 開國方略 хэмээх хятад нэрээр алдаршсан Чин гүрний чухал сурвалж, Чингийн Дотоод бичгийн яамны их хэмжээний монгол данс бичиг, XVII зууны Орос, Монголын ард түмний харилцааны талаарх орос сурвалжууд байна. Мөн, тэрээр “Цагаан түүх” зэрэг сайтар мэдэгдсэн монгол он дарааллын тэмдэглэлүүдийг ашиглажээ.

Тэдгээр олон зүйл сурвалж нь өөрөөр бол магад түүний бүхий л тайлбарт (interpretation) саад тотгор учруулахуйц, XVII зууны түүхийн талаарх зарим нийтлэг ойлголттой тэмцэх боломжийг Мөнх-Эрдэнэд олгожээ. Тухайлбал, Чин улс Монголыг байлдан дагуулсан гэх ерөнхий ойлголт (broad assumption) тухайн үгийн ямар ч утгын хувьд няцаагдаж байгаа нь нэн чухал. Монголыг байлдан дагуулсан талаарх Чингийн хэвшмэл түүх бичлэгт өгүүлснээр, уг үйл явцад эргэлт гарсан анхны мөч нь Лигдэнгийн эсрэг тэмцэл, түүний ялагдал, Цахарын хаант улсыг захиргаандаа оруулсан явдал юм. Энэ үйл явдлыг товойлгосон нь магад Саган Сэцэний “Эрдэнийн товч” (1662) хэмээх түүхээс үүдэлтэй юм. Тус бүтээл хэр үнэн эсэх нь 1829 онд Европын (герман) хэлэнд анх орчуулагдсанаас хойш эргэлзээ дагуулсаар ирсэн юм. Энэ зохиолын оргил хэсэг нь Лигдэнгийн үхэл бөгөөд түүнийг нь 1634 онд Цахарыг Чинд нэгтгэх нь зөв болохыг бүрэн дэмжсэн тангарагт дайсан нь бичсэн юм (Саган Сэцэн [Цахарыг Чинд

нэгтгэхийг] дэмжсэн байр суурийнхаа төлөө Чин гүрний ордноос өгөөмөр шагнал хүртсэн юм). Хэвшмэл түүх бичлэгт [сурвалжийн] тусгайлсан мэдэгдлүүдийг (specific claims) няцаах нь тус бүтээлийн гурван бүтэн хувилбарын хоорондахь зөрүү хийгээд хамгийн их хэрэглэгддэг, манж ба хятад хэл дээрх орчуулгуудын алдаа мэдгийг судлахтай адил том асуудал биш байсаар ирсэн. Гэвч Мөнх-Эрдэнэ тэдгээр техник шинжтэй асуудлуудыг бус, харин ондоо асуудлыг сонирхжээ. Түүний нягталснаар, тухайн үеийн орос албан захидлуудын мэдээ баримт Лигдэнг хөнөөсөн төрийн эргэлтийг Саган Сэцэн өөрөө толгойлсон бөгөөд уг үйл явдал Лигдэн Чингээс зайлан баруунш зугтах үед бус, харин цэрэг удирдан Хөх нуур (Чинхай)-ыг дайлж байх үед тохиосныг харуулжээ. Үүнээс үзвэл, түүнийг хөнөөсөн алуурчид өөрсдөө Чинд буун өгчээ. Эдгээр залруулгын (emendations) үндсэн дээр Мөнх-Эрдэнэ Чин улс Лигдэнг ялсан хэмээх түүх бичлэгийн хэвшмэл ойлголтын үндэс суурь няцаагдсан тул одоо харин жинхэнэ түүхийг өгүүлж болно гэж үзжээ. Чингийн эзэн хаан болохынхоо өмнө Айсин гүрэн (олон түүхч “Хожуу Жин” хэмээн нэрлэдэг улс)-ий удирдагч Хун Тайж Лигдэнгийн эсрэг дайнд монгол тайж нартай хүчээ нэгтгэжээ. Лигдэнгийн эсрэг монгол тайж нарын эн тэнцүү холбоотныхоо хувьд Хун Тайж үндсэндээ тайжийн төрийн үндсэн зүй ёсыг (constitutional legitimacy) даган баримтласан аж. Иймээс Чин гүрэн Монголыг эзлээгүй. Оронд нь Чин өөрөө Монголын язгууртны улс төрийн институтуудын өргөтгөл (extension) байсан бөгөөд энэ нь Манжийн найман хошууны язгууртны хамтын засаглал (aristocratic collegial governance)-д тусгалаа олсон байсан бөгөөд чухам ийм шинж чанартай байгууламж (entity) Хятадыг байлдан дагуулахаар мордсон аж.

Энэ нь Мөнх-Эрдэний номондоо бүтээсэн түүх бөгөөд энэ нь түүний чиг хандлагыг түүхч гэхээсээ социологич гэхээр харагдуулж байна. Номын зарим хэсэгт үйл явдлуудын он цаг, тэр бүү хэл зарим хүнийг тусгайлан заахгүйгээр бичигдсэн хэсгүүд байгаа нь үүнийг илтгэнэ. Ялангуяа, зохиогчийн засварлагч судалгааны төсөл (revisionist project) нь шинэ нотолгоо гаргахаас илүүтэй Чингээс Монгол язгууртуудтай тогтоосон харилцааны талаарх хэвшмэл түүх бичлэгийн цаадах онолын гол ойлголтуудыг тодруулан тайлбарлаж, өөрчлөхөд чиглэсэн байна. Хэдийгээр зохиогч номынхоо гарчигт хэрэглэсэн “constitution” гэх ухагдахууныг огт ил тодорхойлоогүй боловч тэр үүгээр Монгол дахь хамтын төр (collegial government)-ийн хэлбэрийг бүтээсэн нийгэм, шашин, цэрэг, улс төрийн уламжлалыг (practice) зааж байгаа нь тодорхой бөгөөд тэр уламжлал Чингээр үргэлжилж, XX зууны эхэн хүртэл эзэнт гүрний хууль цааз, бодлогын эх үүсвэр болж байжээ. Энэ санал (thesis) нь Еврази, Ляо гүрэн, Чингисийн угсааныхны хууль цааз, улс төрийн институтуудын талаарх Мөнх-Эрдэнийн хэвлүүлсэн судалгаануудад нэлээд тулгуурласан Монголын улс төрийн түүхийг эргэн нягтлах (review)

шаардлагыг бий болгож байна [1]. Зохиогчийн тайлбарлаж буйгаар, Чингийн өмнөх үеийн их өрнөл нь Умард Юань улсад “тайшийн төр” (taishi government)-ийг үгүй хийж, “тайжийн төр” (taiji government)-өөр сольсон үйл явдал байжээ.

Эсэн тайшаар жишээлсэн тайшийн төр нь түүн шиг магад Чингисийн бус угсааны хүчирхэг цэргийн удирдагч хааны нэрээр цэрэг, санхүүгийн институтыг захирах үүрэг хүлээдэг засаглах арга (political mode) байжээ. Гэвч Эсэн (Саган Сэцэний зохиолд товойсон дүр) төрийн хэргийг буруу явуулж (Мин улсын эзэн хаан Жү Чижэнь (1436-1450, 1457-1464)-ийг олзлон хорьсон нь үүнд хамаарна), улмаар Чингисийн залгамжлагчдыг устгах, өөрөө Умард Юанийн хаан болохыг оролдсоноор алдаа гаргасан байна. Энэ үйл явдлыг даган өрнөсөн Чингисийн угсааныхны эсрэг тэмцэлд Эсэн эцэстээ өөрийн дэмжигсэддээ алагджээ. Дараа нь Даян хааны удирдлагаар Чингисийн угсааныхан байр сууриа сэргээж, Эсэнд эрх мэдэлд хүрэх боломж олгосон улс төрийн уламжлалыг халсан байна. Улмаар хааны ургийн язгууртнууд (imperial lineage) болон эзэн хаан (ruler) хамтдаа эзэн эрхт нэгэн байгууламжийг (one sovereign entity) бүтээжээ. Энэ байгууламж нь 1634 онд Чин гүрэн Лигдэнгийн Цахарын эзэн хаан-язгууртнуудын гэрээт байгууламжид (Chakhar ruler-aristocracy compact) Лигдэнгийн орыг эзлэхийн суурь болж өгчээ. Улмаар уг байгууламж нь Айсин хаант улсын зохион байгуулалтыг бүрэн өөрчилж 1636 онд Чин гүрнийг тунхагласан байна. Зохиогчийн онцолсноор, энэ үйл явцаас бүрэлдсэн төр нь Цахарын улс төрийн байгууламжийг (Chakhar polity) дуурайсан ч биш, эсвэл түүнээр сэдэлжсэн буюу нөлөөнд нь автсан ч биш, харин Умард Юань-Цахарын тайжийн төр (Northern Yuan-Chakhar taiji state)-ийн органик үргэлжлэл байсан. Тайжийн төр нь Даян хааны үеийн алтан ургийнхны хувь эзэмшил (буюу appanage) залгамжлагчид болох Монголын тайж нартай байгуулсан мөнхийн холбоонд (perpetual alliance) суурилжээ. Үүний сацуу монгол тайж нартай байгуулсан холбоог амьд хадгалж байх нь Чингийн төр номын ба эгэл ертөнцийн “хоёр ёс”-ны чакравартийн ёсоор төр барих шашны үзэл суртлыг хөгжүүлэхэд хүрсэн байна. Мөн, энэ харилцаа нь Чингийн эзэн хаан Занабазар хутагт хийгээд Юнхэгүн сүмийг ивээлдээ авсан болон Түвдийн (ялангуяа Гэлүг ёсны) шашны ёслолын зан үйлийн бүтээлүүдийг хэвлүүлж, мэдээллийн бүхий л сувгаар шашны урлагийг сурталчилснаар илрэлээ олсон.

Монгол язгууртнууд болон Чингийн эзэн хааны ургийнхны цаашид үргэлжилсэн түншлэл (extended partnership) нь уг чанартаа (1651 онд бичгээр албан ёсжсон) Чин гүрний конституци (constitution) байжээ. Зохиогчийн үзэж буйгаар, Чингийн бүх эзэн хаан түүнийг даган мөрдөж, “эх хууль” (original law) болгон ишлэдэг байсан (352-р хуудас). Мөн, тэд XVII-XVIII зуунд Монголд харц гаралт ихэрхэгчдийн (upstarts) толгойлсон бослогуудыг дарахдаа тэрхүү хуульд найджээ. Чингийн өмнөх үеийн Монголын арван таван хууль цаазыг (угсаа

залгамжилсан эзэмшил бүхий арван таван язгууртан буюу тайжийн хууль цаазыг) судалсны үндсэн дээр зохиогч энэхүү төр нь “язгууртны парламентын конституцат хаант төр” (aristocratic parliamentary constitutional monarchy)-ийн онцлогтой байсныг тодорхойлжээ (12, 20-р хуудас). Монгол дахь Чингийн империалист үзлийн тэргүүлэх монгол магтан дуулагч гэгддэг Ломи нь тайж нар хийгээд Чингийн эзэн хааны хооронд байгуулсан конституцат гэрээ (constitutional compact)-г дэмжигч бөгөөд гэрээ ердөө өчүүхэн төдий зөрчигдөхөд л Чинг шүүмжлэгч болон хувирч буйг зохиогч харуулжээ. Зохиогчийн харуулснаар, Ломи нь Чингийн байгаагүй/болоогүй империализмыг магтан дуулагч бус, харин тайж-Чингийн конституцат суурилсан улс төрийн ёсзүйн шүүгч (arbiter of political ethics) аж. Чин гүрэн нь мөн Айсингиоро угсааны язгууртнуудыг “дотоод” (331-р хуудас) хүрээ, Чингисийн угсааны тайж нарыг “гадаад” (301-р хуудас) хүрээ хэмээн хүлээн зөвшөөрсөн хос төрт улс (dual state) байжээ (энд “гадаад” нь Лифан юань 理藩-аар дамжин харьцдаг гэснээс эзэнт гүрний гадна гэсэн утга санаагаар хэрэглэгдээгүй). Энэхүү статус кво нь Чингийн эзэн хааны ордон тэрхүү эртний үндсэн хуульт байгууламжийг орчин үеийн иргэний үндсэн хуульт хаант төрөөр халах шинэчлэл эхлүүлж, хятад элитүүд хийгээд гадаадын засгийн газруудыг тайвшруулахыг оролдсон ХХ зууны эхэн үе хүртэл хэвээр байжээ. Эл өөрчлөлт нь Чингийн нэгэнт тогтсон эх хуультай зөрчилдөж буйг Монголын тайж нар даруй зааж, улмаар энэ нь эзэнт гүрэн задарсан хэрэг хэмээн үзэж 1910 онд Монголын тусгаар тогтнолыг зарласан гэж зохиогч дүгнэсэн байна.

Дээрх хураангуй нь “Тайжийн төр” ном ревизионист чиг хандлагыг онцгой бөгөөд шинэ түвшинд аваачихын сацуу олон суурь санаанууд нь Чин гүрний түүхийн судалгаан дахь сүүлийн үеийн чиг хандлагуудтай адил байгааг магад харуулж байгаа юм. Чин гүрнийг судлагч олон шилдэг түүхч Чин нь төрийн сууриа Цахараас шууд авсан олон бүрдэлт төр (segmented state) гэж үздэг юм. ХХ зууны эхэн үеэс өрнийн хэлүүдээр бичигдэж эхэлсэн түүх бичлэгийн сэтгэлгээний энэ чиг хандлага нь өнгөрсөн хориод жилд сэргэж, улам нарийн боловсронгуй болж байгаа юм. Энэ дашрамд хэлэхэд, би урьд хэвлэгдсэн болон удахгүй хэвлэгдэх бүтээлүүддээ Чинг олон засгийн газраас бүрдсэн төр (state composed of multiple governments) гэж тодорхойлсон бөгөөд тэдгээрийн нэг болох Лифан юань нь анхандаа Монголын хэргийг тусгайлан эрхлэх чиг үүрэгтэй байсан юм. Чинг судлагч бусад түүхчид Чингисийн угсааны (ялангуяа Боржигид угсааны) язгууртнууд эрх мэдэл, тусгаар байдлаа үргэлжлэн хадгалсныг (continuing power and independence) ерөнхийдөө зөвшөөрдөг бөгөөд Мөнх-Эрдэнийн аргууд нь Чингийн төрийн онцлогуудыг тодорхойлсон өнөөгийн судалгааны бусад олон чиг хандлагатай нийцэж буйг ч анзаарах болно. Гэвч Мөнх-Эрдэнэ өөрийн онол-арга зүйтэй ижил төстэй хандлагууд орчин үеийн түүх бичлэгт

урьд нь байсан буюу Чингийн талаарх өнөөгийн судалгаануудад нэлээд байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс эрс татгалзаж байна. Заримдаа энэ үгүйсгэл нь олон уншигчдын хувьд эрс санал зөрдөг түүхчдийг хамтад нь нэгэн бүлэг болгон ангилснаар биелжээ.

Түүхчдийг бүлэглэх Мөнх-Эрдэнийн логикийг нягтлах нь чухал. Түүний үзэж буйгаар, Чингийн төр буюу улс төрийн соёлд зарим “манж” бүрдэл байсан гэж боддог түүхчид хүртэл хятад төвт үзлийн нөлөөнд байна. Учир нь, тэд Чин нь Монголыг эзэмшилдээ (dominion) байлгаж, Хятадаас захирч байсан хэмээн өгүүлж, XVIII зуунд Монгол дахь Чингийн захиргааны институтуудад (цаад утгаараа Түвдэд байснаас илүүтэй) бюрократ (түшмэл ёсны) тогтолцоог нэвтрүүлсэн гэж үзсэнээрээ монгол язгууртнуутай байгуулсан гэрээгээ үргэлжлүүлж байсан Чингийн төрийн үндэс суурийг үгүйсгэж, хятад гаралтай засаглалын системээр орлуулжээ. Жишээлбэл, Жан Шимин Чин улсын доторх Найман хошууг язгууртны төр хэмээн тодорхойлсноороо олон уншигчийн хувьд Мөнх-Эрдэнийн саналд дэмжлэг үзүүлсэн гавьяатай баймаар боловч XVIII зууны дунд үе гэхэд бюрократ тогтолцоо нь Найман хошууны “түшмэг” (vassal) улсын ихэнх үндэс суурийг үгүй хийсэн гэж мэтгэсэнээрээ хятад төвт үзэлтэн болж үгүйсгэгджээ. Эсрэгээр, Мөнх-Эрдэнэ Найман хошуу хийгээд Монголын тайжийн төр нь Чин гүрэн мөхөх хүртэл язгууртны хамтын гэрээгээ мөрдсөн гэж үзэж байна. Үүгээр зогсохгүй, эзэнт гүрнүүд нь тодорхойлолтын хувьд ямар нэг соёлын хязгаараас хэтийдсэн байдаг бөгөөд энэ нь Евразийн байлдан дагуулагч эзэнт гүрнүүдийн зэрэгцээ засаглал (simultaneous rulerships) үүсэхэд суурь нөхцөл болсон гэх үзлийг тууштай баримталдаг мань мэтийн түүхч хүртэл Чингийн үед Монгол дахь төрийн суурь үндсээрээ өөрчлөгдөөгүй болохыг бүтээлдээ өгүүлээгүйн төлөө “хятад төвт” үзэлтэн гэгдсэн байх юм.

Хэдийгээр би түүхчдийг бүлэглэх энэ зуршил XX, XXI зууны Чингийн жинхэнэ түүх бичлэгийг гуйвуулсан бөгөөд төлөөлөхгүй гэж үзэж буй ч ямартай ч Мөнх-Эрдэнийн байр суурийг Чин гүрнээр мэргэшсэн аль ч улсын судлаачид нухацтай авч үзэхийг чухалчлан зөвлөмөөр байна. Ихэвчлэн сурвалжийн баримтаар нотлогдоогүй ч, хятад төвт ойлголт (Chinese-centered assumptions) одоо ч Чингийн үеийн талаарх бидний үзэл баримтлалд давамгайл байдаг нь оргүй зүйл биш юм. Түүгээр ч барахгүй, эрт үеийн язгууртны улс төрийн бүрдлүүдийн (aristocratic polities) мөн чанарын талаарх бидний ойлгох чадвар (imaginative grasp) ямагт сул байж ирсэн гэдгийг орчин үеийн түүхчдэд ерөнхийд нь сануулах хэрэгтэй юм. Чингийн институтууд болон улс төрийн соёлын талаарх монгол сурвалжид тулгуурласан түүх бичлэг хүчтэй хөгжсөн ч, миний үзэхээр Мөнх-Эрдэнэ монгол язгууртнуудтай тогтоосон үргэлжилсэн органик харилцаа нь Чин гүрний төрийн үндсэн зарчим (central controlling principle) байсан гэх саналыг англи хэлээр анх удаа дэвшүүлжээ. Улмаар дэвшүүлсэн санал нь орчин үеийн түүх бичлэгт сорилт (challenge) учруулж байна. Хэрвээ

би Мөнх-Эрдэнийн дэвшүүлсэн саналын өнцгөөс түрүү үеийн Чингийн талаарх өөрийнхөө үзэл баримтлалыг авч үзвэл (өөрөөр хэлбэл, бусад бүх түүхчийг “хятад төвт” үзэлтэн гэж ангилсныг нь орхиод, тэдний бичсэн зүйлийг тухай бүрд нь тусгайлан авч үзвэл), Цахар-Айсингийн нийлбэр нь Чин гүрнийг бүтээж, зэрэгцээ засаглалыг (simultaneous rulership) (Чингисийн угсааны хаан (khagan), Зүүн хойдын хан (khan), Хятадын эзэн хааны (emperor)) үүсгэсэн гэсэ миний тайлбарт (interpretation) (Чингисийн угсааны) хаан нь уг зэрэгцээ засаглалын (rulership) дотор бие даасан тал (independent persona) болж (XVIII зуунаас монгол ижилслийг (Mongol identity) тодорхойлоход ерөнхийдөө бие даасан үүрэгтэй) байсныг харуулах юм. Энэ нь Монгол хааны язгууртнуудын түүхэн бүрэлдэхүүн хийгээд Чингийн удирдагчийн хооронд тогтсон харилцан биенээ тодорхойлох, харилцан биенээ легитимжүүлэх харилцааны талаарх Мөнх-Эрдэнийн саналаас их ялгаатай юм. Энэ харилцаа нь Монгол дахь Чингийн засаглалыг Чингийн дараах монгол ижилсэлтэй (post-Qing Mongol identity) тун өөрөөр холбох юм. Зохиогч энэ асуудлыг тусгайлан үзээгүй боловч нэгэнт түүний дэвшүүлсэн аргууд нь уг номонд авч үзсэнээс илүү их үр дагавартай байж болох тул зохиогч ирээдүйд үүнийг авч үзнэ гэж найдаж байна.

Түүх бичлэгийн талаарх зохиогчийн үнэлэлт дүгнэлтийн цаадах логик нь Чингийн үеийн Монголын засаглал болон, уг засаглал нь эзэнт гүрний конституцитай хэрхэн холбогдсоныг задлан шинжилсэн судалгааных нь үнэмшил төрүүлэхүйцээс (persuasiveness) тусдаа асуулт юм. Бюрократжилт нь Мөнх-Эрдэнийн хувьд ноцтой асуудал. Дорнод Евразийн хувьд тэрээр бюрократжилтыг эртний Хятадад үүссэн засаглалын өвөрмөц хувилбар болох эзэн хаан төвт засаглалтай (emperor-centered governance) адилтгажээ. Зүүн хойд Ази, Манжуур, Монгол, Туркестан, Түвд, Зүүн өмнөд Азийн бүх нийгмүүд эрт үеээс язгууртнуудын хамтын засаглал (collegial aristocracies) хийгээд тэдний зөвшилцлөөр тодорсон удирдагчтай (consensual leader) тогтоосон тэдний харилцаанаас үүссэн институт бүхий төртэй байсан учраас язгууртан-удирдагчийн гэрээг тасалдуулж, түүнийг эзэн хааны засаглалаар (emperorship) солиход чиглэсэн бюрократжилтын дэвшил (progress of bureaucratization) нь Мөнх-Эрдэнийн тодорхойлолтын хувьд “хятаджилт” болж байна (26-р хуудас). Түүний парадигмаар, “монгол”, эсвэл “манж” бюрократжилт гэж байхгүй, харин зөвхөн импортын хятад институтууд нийгэм, оюун санаа, улс төрийн хувьд нэгдсэн язгууртны төрийг сүйтгэх буюу үгүй хийх үйл явц гэж байж болох. Чингийн үеийн Монголд энэ үйл явц болоогүй гэж Мөнх-Эрдэнэ үзжээ. Түүний үзэж буйгаар, өмнөх үеийн түүхчид бюрократ шинж чанаруудыг Чингийн үеийн институтууд, ялангуяа хамгийн чухал нь болох аймаг, хошуунд оновчгүйгээр хамаатуулжээ. Өмнөх үеийн түүхчдийн энэ ойлголтыг (assumption) нягтлахдаа зохиогч XVIII зууны Монголын бараг бүх түүх бичлэгт

тухайлбал аймгийг өмнө нь оршин байсан тайжийн төрийн улс төрийн зохион байгуулалтыг халсан Чингийн (сэдсэн/зохиосон биш бол) тохоосон институт байсан мэтээр алдаатай дүрсэлсэн гэж мэтгэж байна. Мөнх-Эрдэнэ Чингийн үеийн аймаг нь үнэндээ тайж хийгээд Чингийн ордны харилцан ашигтай холбоогоор дамжин үүссэн язгууртны институт байсан нь тодорхой гэж дүгнэжээ.

Мөнх-Эрдэнийн хувьд Чингийн үед Монгол нь Даян хааны үед үүссэнээсээ хойш дорвитой өөрчлөгдөөгүй уламжлалт хамтын институтуудад суурилсан төртэй хэвээр байсан гэдгийг нотлох нь нэн чухал аж. Алтангийн бий болгож, Чингисийн бус угсааны эрх баригчдын хэрэглэж ирсэн хутагт хувилгаадын теократ засаглалын загвар ч дээрх тогтолцоонд өөрчлөлт оруулаагүй аж. Харин утга учир бүхий цорын ганц өөрчлөлт нь тайж нарын харилцаа нь өмнөх зуунуудад Монголыг захирч байсан Чингисийн угсааны эзэн хаанаас Чингийн эзэн хаан (1636 онд эзэнт гүрэн байгуулагдсанаас хойшхи бүх эзэн хаан нь Боржигидын хойчис) руу чиглэсэн явдал ажээ. Монгол дахь тайжийн төр тасалдалгүйгээр үргэлжлэн оршин тогтносон төдийгүй энэ нь Чингийн төрийн гол үнэт зүйлсийн үндэс суурь буюу конституци болжээ. Энэ асуудал дээр Мөнх-Эрдэнэ Чин нь Монголыг захирахдаа уламжлалт элитүүдийг хүчгүйдүүлж, өөртөө дуулгавартай монгол язгууртнууд хийгээд шашны удирдагчдыг тавихын тулд улам бүр бюрократ тогтолцоог өөрийн хамгийн үр ашигтай хэрэгсэл болгон ашигласан хэмээн мэтгэдэг Дэвид М. Фаркухар, Христопер П. Этвүүд, Никола Ди Космо, Иохан Элверског, Петер Пердью, Жан Шимин болон бусадын (бүхэлдээ хятад төвт үзлийг баримтлаагүйн төлөө Ока Хирокид зарим гавъяа ногдсон) эсрэг өөрийгөө сэргүүлэн тавьжээ.

Мөнх-Эрдэнийн тайлбар (interpretation) нь бүхэлдээ итгэл үнэмшил төрүүлэхүйц байхын тулд (миний үзэхээр, энэ нь үнэ цэнтэй түүх бичлэгийн эцсийн шалгуур хэзээ ч биш) Чингийн үеийн Монгол хийгээд Чингийн төрийн түүхийн нотлогдох боломжийг (attested qualities) харуулах (predict) чадавхитай байх ёстой юм. “Алтангийн теократ хаант төр, лам-өглөгийн эзний харилцааны төгс бүтээгдэхүүн” (435-р хуудас) болох Галдангийн талаарх түүний судалгаа нь Галдангийн үйл ажиллагааг Халхын удирдагчид, Чин (эсвэл, хувь хүнийх нь хувьд эзэн хаан Канши 康熙)-гийн тус тусын эсрэг чиглэсэн бус, харин монгол тайж нар хийгээд Чингийн эзэн хаадын хамтын улс төрийн байгууламж (combined polity)-ийн эсрэг хийсэн цэрэг, улс төр, оюун санааны дайралт байсан гэж уг үйл явдлыг гүн гүнзгий, нарийн учир шалтгааных нь хамт үнэмшилтэйгээр гаргажээ. Энэ нь Чингийн үеийн Монголын уламжлалт түүх бичлэгийг дорвитойгоор сайжруулсан хэрэг юм. Эзэн хаан Канши (1662-1722)-гийн хаанчлалын сүүлийн арван жилд VII Далай ламыг тодруулах эзэн эрхийг тодорхойлхуйц өрсөлдөөний талаарх Мөнх-Эрдэнийн нарийвчлан өгүүлсэн түүхийн тухайд мөн дээрхтэй ижил зүйлийг хэлж болно. Гэвч, номын түүхэн агуулга XVII зуун руу ихэд хэлбийсэн хэрнээ XVIII, XIX

зууны хувьд зөвхөн үзэл суртлын өөрчлөлтийг бүдэгхэн харуулсан, эсвэл энэ талаар огт өгүүлээгүй байна. Монгол дахь Чингийн нөлөөг сулруулахын тулд Оростой холбоо байгуулах, эсвэл зайлшгүй тохиолдолд дагаар орохоор удаа дараа хийсэн монгол язгуурнуудын оролдлогыг XVIII зууны хувьд авч үзсэн хэрнээ XVII зууны хувьд (зүй нь Чингийн конституци бүрэлдэж байсан үед) авч үзээгүй байна. Нөхцөл байдалд сэтгэл дундуур монгол тайж нар (1686 онд Түшээт хантай адил) Чингийн ордонтой хийж буй хэлэлцээнд Далай ламыг хөндлөнгөөс оролцуулахаар хандсан тохиолдлууд гарсан нь конституцийн хувьд ирээдүйн ямар үр дагавруудтай байсныг тайлбарлаагүй байна. Мөн, зохиогч монгол тайж нар эзэнт гүрний шинэчлэлүүд эрх мэдлийг нь сулруулж байгааг мэдэгдэн Чинг эсэргүүцсэнээ зөвтгөсөн, 1756-1757 оны Чингүнжавын бослого гэх мэт үйл явдлуудад анхаарал тун бага хандуулсан байна. Мөнх-Эрдэнэ тэдгээр шинэчлэлүүд чухал нөлөө үзүүлээгүй гэж өгүүлжээ. Тайж нарын хамтын холбоо (taiji collegial alliance) нь оролцогчдоо орлуулан сольж болохуйц байгууламж байсан уу гэх асуулт зайлшгүй тавигдаж байна. Чингисийн ургийнхан болон тэдэнтэй зэрэгцэн буй Чингийн Айсингиоро эзэн хааны ургийнхан ийм конституцийн холбооны зайлшгүй хамтрагчид байсан уу? Тайжийн маягийн конституци нь Романовынхныг тойрон бүрэлдэж болох байсан уу? Мөнх-Эрдэнийн тайлбараар уг харилцаа өөр нөхцөлд шилжих боломжгүй бололтой. Гэвч монгол тайж нарын стратегийн ба дипломат харилцааны түүх ийм шилжилт байж болох байсныг сануулж байгаа юм.

Магад, дэмжлэг авахад илүү хэцүү тал нь гэвэл, Мөнх-Эрдэнэ нэг цаг үе, эсвэл нэг санаа нөгөөдөө хэрхэн нөлөөлснийг тайлбарлахдаа бараг дан (exclusive) шулуун шугмаар харахыг чухалчилсан явдал юм. Түүрүү үеийн Чин гүрэн байгуулагдахад нөлөөлсөн хүчин зүйлсийг ач холбогдлоор нь эрэмблэ гэвэл тун цөөн судлаач Монголын улс төрийн институтууд болон үнэт зүйлсийг (values) дээгүүр эрэмблэхгүй алдаа гаргах юм. Гэвч өөр бусад хүчин зүйлс лавтай бий. Тэдний зарим нь адилхан чухал юм. Мөнх-Эрдэнэ Айсин хаант улсын үеийг нэг их сонирхолгүй, судалгаандаа энэ талаар зөвхөн маш товч өгүүлжээ. Гэвч энэ нь Найман хошуу үүссэн хийгээд түүний язгууртны институт бүрэлдсэн үе байсан юм. Энэ нь мөн Зүүн хойд Ази даяар шууд ба шууд бус нөлөөллүүдийн баялаг хоршил Айсингиорогийн үндэслэгчдэд зарим нөлөө үзүүлснийг харж болох үе юм. Хэрэв Чингийн конституци байсан бол энэ нь магад монгол тайж нартай гэрээ байгуулахаас өмнөх цаг үед Айсингиоро дангаараа бэйлийн статусыг монополчилсноос үүссэн байж болохгүй гэж үү? Төрийн ёс суртахууны энэ төрлийн үндэс суурь (moral basis) нь тайжийн хамтын төртэй тун адил харагдаж болох хэдий ч дорнод Монгол, Солонгос хийгээд Хятадын эзэн хаант төрийн нөлөөгөөр (Ляодунаар дамжин) Манжуурт нэвтэрч, хувиран нутагшсан хуучин уламжлалаас үүссэн байж болох юм.

Дээр миний илэрхийлсэн тээнэгэлзэлд Мөнх-Эрдэнэ бүс нутгийн улс төрийн уламжлалуудын дотроос Цахар улс Айсинд хамгийн их нөлөөлсөн тул 1634 оны дараа Цахар, Айсингийн нэгдлээс бүхэлдээ шинэ төр үүссэн гэдгийг онцолсон хариулт өгч магад. 1636 онд эзэнт гүрэн байгуулагдсан үйл явцыг эхлүүлсэн хүчин зүйл нь зөвхөн Монголын шууд нөлөө байж ч магадгүй юм. Гэтэл энэ нь Мөнх-Эрдэнийн аргументын бас нэг бэрхшээлтэй талыг л сэдэрээж байна. Цаг хугацааны явцад гарсан өөрчлөлт, хувиралт уг номонд орхигдоогүй боловч зөвхөн ач холбогдол бага, төвөг удсан байдлаар илэрхийлэгджээ. Мөнх-Эрдэний судалгаа харуулж буйчлан, ямар нэгэн өөрчлөлт гарсныг харуулахаас өөрчлөлт гараагүйг харуулах нь хавьгүй хэцүү юм. Харин би Айсингийн төр нь Ляодунд орсны дараа өөр төр болсон ба Цахартай үүсгэсэн зөрчлийг шийдсэний дараа дахин өөр төр болсон бөгөөд Чин нь Цагаан лянхуагийн дайн (1796-1895)-ны дараа дахин өөр төр, Тайпины дайн (1851-1864)-ны дараа дахин өөр төр, Жиангийн дайн (1894-1895)-ны дараа дахин өөр төр болсон гэж мэтгэнэ. Би ганц конституцийн ёс зүй (constitutional ethos) 1630 оноос ХХ зууны эхний жилүүд хүртэл Чинг оршин тогтноулсныг хүлээн зөвшөөрөхийн тулд Чингийн түүхийн үлэмж хэсгийг мартаж хэрэгтэй болох нь. Өөрчлөлт мэдээж тохиосныг Мөнх-Эрдэнэ зөвшөөрч байна. Тэрээр Найралт төвийн хаанчлалын (1723–1735) үед Монголыг хамран хэрэгжсэн хилийн засаг захиргааг төвлөрүүлэх аажим бөгөөд тогтвортой хөтөлбөрийг онцолжээ. Үүгээр уламжлалт элитүүдийн нөхөрлөл болон тэднийг оршин тогтноулж байсан нийгэм-эдийн засгийн бүтцүүдийг иргэний засгийн газрын хэлбэр хийгээд албан хаагчдаар сольсон нь олон уншигчийн хувьд бюрократчлал байх учиртай юм. Мөнх-Эрдэнэ Найралт төвийн тэдгээр шинэчлэлүүдийг хүлээн зөвшөөрч байгаа боловч Монголын тухайд өмнөх үеийн түүхчид Чингийн шинэчлэлүүдийн ач холбогдлыг хэтрүүлсэн, хамгийн гол нь Чингийн төр өөрөө монгол тайж нарын бие даасан байдал хийгээд статусд халдах аливаа аюулыг үргэлжид засан зайлуулж байсныг магад ойлгоогүй гэж үзэж байна. Зохиогчийн үзэж буйгаар, Чингийн эзэн хааны ургийнхан өөрийн хууль ёсны эрхийг үнэнч байдлаа сайн дураар үргэлжлүүлэн харуулж хариуд бие даасан холбоотны хувиар хандахыг шаардсан тайж нарын чадварыг хадгалж байхаас хамааралтай гэж харж байжээ.

Уусалт (assimilation), хэвшилт (routinization), мэргэшилт (professionalization), хуульчлалт (legalization) зэрэг хэвшмэл парадигмуудын эсрэг сөрсөн энэхүү анхааруулга нь “Тайжийн төрийн” онцгойрон ялгарсан сайн чанаруудын нэг юм. Уншигч уг бүтээлийг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн ч бай, үгүй ч бай, уламжлалт ёс нь харизмтайгаа, оюун санааны хүчтэйгээ, “өнөө үеийн” улс төр, соёл, сэтгэлзүйн орчинтой нэг нэгнээ нөхөн сэргээдэг харилцан үйлчлэлтэйгээ орчин үе хэмээх үе хүртэл үргэлжилсээр ирсэн гэх аргументтай аргагүйн эрхэнд эвлрэх нь эрүүл, таатай үзэгдэл юм.

“Тайжийн төр”-ийг анхааралтай уншсан, Чин, Монгол, эсвэл Дотоод Азиар мэргэшсэн ямар ч судлаач байлдан дагуулал, эзэнт гүрэн, эсвэл Монголын тухай улиг болсон ойлголтуудыг (generalizations) няхуур шүүмжгүйгээр хүлээн авах боломжгүй юм.

Орчуулсан П.Мягмар

Англи хэл дээрх шүүмж:

<https://www.cuhk.edu.hk/ics/journal/articles/v76p189.pdf>

[1] Тухайлбал дараахыг үзнэ үү: “The 1640 Great Code: An Inner Asian Parallel to the Treaty of Westphalia,” *Central Asian Survey*, 29.3 (2010); “Political Order in Pre-Modern Eurasia: Imperial Incorporation and the Hereditary Divisional System,” *Journal of the Royal Asiatic Society*, 26.4 (2016); “In Accordance with the Great Törü: Pre-Modern Mongol Concept of Moral Order, Law and Government,” *Proceedings of the Eleventh International Congress of Mongolists* (2017)